



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/625

Хэрлэн сум


“Эрчүүдийн үнэт зүйлс эрүүл мэнд”
өдөрлөгт дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 99 дүгээр тогтоолын 2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Эрчүүдийн үнэт зүйлс эрүүл мэнд” өдөрлөгийн арга хэмжээг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Чингис хотод зохион байгуулахад 2,470,000 (хоёр сая дөрвөн зуун далан мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
оны 12 дүгээр сарын 06-ны
дугаар захирамжийн хавсралт

“Эрчүүдийн үнэт зүйлс эрүүл мэнд” өдөрлөгийн зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1.	Багш нарын томилолт	125,000	2	250,000
2.	Буудлын зардал	110,000	2	220,000
3	Эрчүүдэд зонхилон тохиолдол эмгэг, түүнээс сэргийлэх арга зам лекцийн үнэ	150,000	4 цаг	600,000
4	Жинхэнэ эр хүн аав хүн лекцийн үнэ	-	2 цаг	500,000
5	Стресс менежмент лекцийн үнэ	-	2 цаг	500,000
6	Тараах материал	1000	400	400,000
	Нийт			2,470,000